



# Торхтой вискиний хөрөнгө оруулалтын танилцуулга

Хамтрагч: Эконтэ болон Хандгай

Бидэнтэй холбоо барих:


Утас: +976-75779444

И-мэйл: [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

[www.orda.mn](http://www.orda.mn)

# Гарчиг

ОРДА-ын тухай .....	3
Хөрөнгө оруулалтын нөхцөл.....	4
Вискиний хураангуй.....	5
Хөрөнгө оруулалтын хураангуй.....	6
Вискинд хөрөнгө оруулах тухай.....	8
Зах зээлийн хураангуй.....	8
Үйлдвэрийн танилцуулга.....	9
Эконтэ ба Хандгай гэж юу вэ?.....	10
Хөрөнгө оруулалтын процесс.....	12
Хөрөнгө оруулалтын үе шат.....	13
Лонхлох тухай.....	13
Хөрөнгө оруулалтаасаа хэрхэн гарах вэ?.....	14
Үйл ажиллагааны процесс ба бидний үйлчилгээ.....	15
Хууль эрх зүйн орчин.....	15
Хууль эрх зүй, татварын орчин.....	15
Кастодиан банк.....	16
Даатгал.....	16
Манай баг.....	17
Бидэнтэй холбогдох.....	18
Түгээмэл асуултууд.....	19
Хөрөнгө оруулалтын анхааруулга.....	20
Хавсралт - 1. Санхүүгийн тооцоолол.....	23



# 1 | ОРДА-н тухай

ОРДА бол хөрөнгө оруулагчдад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, урлагийн бүтээл, ховор цуглуулгын зүйл зэрэг уламжлалт бус хөрөнгүүдийг (альтернатив хөрөнгө) хэсэгчилсэн байдлаар хөрөнгө оруулах боломж олгодог, технологид суурилсан платформ юм. Бид мэргэжлийн болон хувийн, уламжлалт болон уламжлалт бус хөрөнгө оруулалтын хоорондох заагийг арилган, хил дамнасан хөрөнгө оруулалтын татвар, хууль эрхзүйн аливаа хүндрэлүүдийг арилгаж, хөрөнгө, хөрөнгө оруулагч хоёрыг холбох гүүр болохоор зорин хөгжүүлэлтээ хийж байна.

Манай компанийн зорилго нь хөрөнгө оруулалтыг илүү хүртээмжтэй, ардчилсан болгох бөгөөд өмнө нь зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон чинээлэг иргэдийн хөрөнгө оруулдаг байсан ховор бөгөөд тансаг виски, дарс, урлагийн сор бүтээл гэх мэт онцгой, уламжлалт бус хөрөнгүүдэд хүн бүр хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэхэд оршино. Бид технологи болон инновацилаг бизнес загварын тусламжтайгаар хүмүүст тэр бүр нээлттэй биш байсан боломжуудыг нээж, өөрийн санхүүгийн бололцоондоо тохирсон хөрөнгө хуримтлуулах арга замыг бий болгож чадна гэж итгэдэг.

ОРДА нь хөрөнгийн зах зээл энэхүү шинэлэг санаагаараа цахиурын хөндийн нэр хүндтэй, олон улсын тэмцээнүүдийн нэг Startup Worldcup - т оролцож, бүсийн шилдэг 10 стартапын нэгээр шалгарсан бөгөөд БНСУ-ын засгийн газрын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг K-StartUp Grand Challenge 2021 хөтөлбөрийн шилдэг оролцогчдын нэгээр Монгол улсаас анх удаа амжилттай шалгараад байна.

Бид хөрөнгө оруулагчиддаа 2020 оны 3 сараас хойш дараах 5 төрлийн хөрөнгө оруулалтыг амжилттай санал болгосон. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгө;
- Шотланд сингл молт торхтой виски;
- Дотоодын уран бүтээлчдийн сор бүтээлүүд;
- Хаалттай өрийн хэрэгсэл;
- Гарааны бизнесийн хөрөнгө оруулалт.

Энэ удаа бид дээд зэрэглэлийн Шотланд торхтой вискиний 4 жилийн хөрөнгө оруулалтыг Хандгайтай хамтарсан цуглуулагчийн буюу хязгаарлагдмал тооны (Limited edition)) лонхтой вискиний төслийн хамт санал болгож байна.

## а. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НӨХЦӨЛ\*

Нийт татан төвлөрүүлэх дүн	£9,940.00
Нэгж эрхийн тоо ширхэг	994.00 ш
Нэгж эрхийн үнэ	£10.00
1 хүний худалдан авах дээд хэмжээ (49%)	487.00 ш
Хөрөнгө оруулалтын хугацаа	4 жил
Лонхлох онууд	2022 ба 2025

## б. Вискиний хураангуй


Виски үйлдвэрлэгчийн нэр	Blair Athol
Викиний бүс	Highlands
Торхны төрөл	Hogshead
Вискиний насжилт	11
Үйлдвэрлэгдсэн огноо	2010/03/05
Нийт лонхны тоо	238
Алкахолны хэмжээ	58.04%
Үнэ (GBP)	£8,500.00

*\*Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй тооцооллыг үзнэ үү.*

## с. Хөрөнгө оруулалтын хураангуй танилцуулга

ОРДА нь дээд зэрэглэлийн Шотланд торхтой вискиний 4 жилийн хөрөнгө оруулалтыг Хандгайтай хамтарсан цуглуулагчийн буюу лимитед эдишн лонхтой вискиний төсөлтэй хамт санал болгож байна. Энэ хөрөнгө оруулалтаар та өндөр өгөөжтэй торхтой вискинд хөрөнгө оруулахаас гадна уг торхтой вискиг 2022 ба 2025 онд лонхолж зарсан орлогоос 2 удаагийн ногдол ашиг хүртэх онцлогтой юм.

Blair Athol үйлдвэрийн талаар товч танилцуулвал:



- Bell's виски болон Johnnie walker-ийн гол бүрэлдэхүүн;
- Diageo-ийн эзэмшилд байдаг нь энэхүү брэндийн том давуу тал бөгөөд Diageo нь дэлхийн алкогольны борлуулалтын 42%-ыг эзэлдэг дэлхийн хамгийн том үйлдвэрлэгчдийн нэг юм. Diageo-ийн эзэмшилд байдаг бусад алдартай брэндүүдээс дурьдвал: Jonnie Walker, Smirnoff, Bailey's, Guinness, Bell's, Mortlach гэх мэт олон төрлийн олон улсад алдартай брэндүүд бий.

## Өгөөжийн хураангуй танилцуулга

Вискиний үнэ	£8,500.00
.....	
Зардлууд:	£1,440.00
• Хадгалалт ба даатгал	£65.00
• Кастодианы шимтгэл	£69.97
• Хөрөнгийн удирдлагын шимтгэл	£696.99
• Ерөнхий удирдлагын зардал	£608.04
.....	
Татан төвлөрүүлэх нийт дүн	£9,940.00
.....	
Ногдол ашиг	£5,008.92
.....	
Татварын өмнөх цэвэр ашиг	£3,568.91
.....	
Татвар	£325.83
.....	
Татварын дараах цэвэр ашиг	£3,243.08
.....	
Нийт өгөөжийн %	32.63%
.....	
Жилийн өгөөжийн %	8.16%

*\*Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй тооцооллыг үзнэ үү..*

## 2 | Вискинд хөрөнгө оруулах тухай

### а. Зах зээлийн хураангуй

Шотланд вискиний бизнес 200 гаруй жилийн өмнөөс хөгжиж эхэлсэн бөгөөд түүнээс хойш олон улс дахь байр суурь нь тасралтгүй өсөн нэмэгдсээр байгаа билээ. Blended буюу холимог виски гарсан нь Highland-аас эхлэлтэй жижигхэн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнүүдийг нэгтгэх, хөгжлийн суурийг нь тавьсан. Харин өнөө үед энэхүү салангид сингл молт бүтээгдэхүүнүүд нь дахин олны анхаарлыг татаж эхэлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд сингл молт вискиний эрэлт тэсрэлттэйгээр өсч, энэхүү зах зээл 2020 он гэхэд 3.8 тэрбум фунт стерлингээр үнэлэгдэж байна. Сингл молт вискиний борлуулалтын хэмжээний (литр) зэх зээлд эзлэх хувь жил ирэх тусам өсөхийн сацуу, борлуулалтын үнэлгээ (Фунт стерлинг) нь түүнээс ч илүү хувиар нэмэгдсээр байна. (Эх сурвалж: Cask 88)

#### Зах зээлийн гол үзүүлэлтүүд:

- Нэг секунд тутамд Шотландаас 36 лонх (700 мл @40% алк.) сингл молт виски дэлхийн 166 орон руу импортлогдож байгаа нь жилийн дүнгээр 1.14 тэрбум болно.
- Шотланд вискин экспорт 2020 онд £3.8 тэрбум байв.
- 2019 онд Шотланд виски нь Их Британийн нийт хүнсний экспортын 21%-иг эзэлж байсан ба нийт барааны экспортын 1.4% -ийг эзэлжээ.
- Шотланд вискиний зах зээл жилд £5.5 тэрбумын нэмэгдсэн өртгийг Их Британийн эдийн засагт оруулдаг.
- Шотланд вискиний үйлдвэрүүдэд жилд 2.2 сая жуулчид зочилдог нь энэхүү салбарыг Шотландын аялал жуучлалын 3 дахь том салбар болгож байна.
- Шотландын агуулахуудад ойролцоогоор 22 сая торх виски хадгалагдаж байна.
- Шотландад одоогоор 134 вискиний үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.



## в. Үйлдвэрийн танилцуулга



Blair Athol-ын хаалгаар ороод л та ид шидийн оронд зочлох болно. Энэхүү гайхалтай үйлдвэр нь Пертширийн хөдөө тосгон Питлокрид байрлах бөгөөд зах хязгааргүй байгалийн үзэсгэлэнт орчинд хийсэн виски нь ч дагаад зөөлөн, тансаг амттай байдаг.

Blair Athol нь энэхүү үржил шимтэй, тансаг байгальдаа өөрсдийн нэрийн амталгааны барыг үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь виски сонирхогчдын очоод хэзээ ч харамсахааргүй аялал жуучлалын цэг болдог.

Амтат Bell's виски болон олон төрлийн Johnnie Walker-ийн гол бүрэлдэхүүн болдог Blair Athol ямар хөрвөх чадвартайг үүнээс нь харж болно. Энэхүү олны танил брэндээс ердөө багахан хувь нь л сингл молт байдлаар зарагддаг нь түүнийг бүр ч илүү эрэлттэй болгож байдаг.

Blair Athol сингл молт лонхтой вискиний нэг гайхалтай жишээ нь 12 жилийн насжилттай, алдарт "Flora and Fauna" цуглуулгын нэг бүрэлдэхүүн юм. Энэхүү үйлдвэр ихэвчлэн Sherry торх ашигладаг тул виски нь бага зэргийн жимслэг амттай болдог. Түүний гол амт нь тоор, алим бөгөөд төгсгөл хэсэг дэх Зул сарын бялуу, самарны төгс зохицол нь хүн бүрт таалагдах зөөлөн, тансаг амтыг бий болгодог билээ.

### с. Эконтэ ба Хандгай гэж юу вэ?

Эконтэ нь Монголын дүрийн болон контентийн салбарыг хөгжүүлэх, залууст сонирхолтой комик, контентоор дамжуулан мэдлэг, зөв хүмүүжил олгох зорилготой продакшн студи юм.



ЭКОНТЭ нь 2003 онд үүсгэн байгуулагдсанаас хойш агуулга, зохиол бүхий контент зохиож, хөгжүүлэх ажилд мэргэшиж ирсэн бөгөөд 100 гаруй комик, контент бүтээгээд байна. Тэдний хамгийн алдартай дүрүүд нь Хандгай, Бумбардай, Бонго нар юм. Бумбардай нь нүүдэлчин ахуй, өв соёл, хүмүүжил боловсролыг дэлхийн хүүхэд залууст зурган ном, хүүхэлдэйн кино, нэвтрүүлгүүдээр таниулан сурталчлахаар бүтээсэн нүүдэлчин баатар билээ.

Тухайлсан агуулгыг сонирхолтойгоор бусдад хүргэх шилдэг арга нь дүрээр дамжуулан хүргэх юм. Дүр нь контентоор амилж, үнэ цэнийг бий болгодог. Та дүрийг хайрлаж, түүнтэй найзалж болно. Хүмүүс хайртай дүрээсээ үлгэр дуурайлал авахад дүрийн үнэ оршдог.

Урт удаан оршин тогтнол: Дүр нь өөрөө хийсвэр ойлголт учир нас нь хязгааргүй бөгөөд сайн агуулга, бүтээлч үйлдвэрлэл байгаа цагт дүр оршин тогтносоор байх болно.



**Дүрийн бизнес:** 21-р зуунд соёлын болон бүтээлч салбар хурдацтай хөгжиж байна. Тэр дундаа контентийн салбар хөгжиж, контентоос үүдсэн дүрүүд бий болж байгаа билээ. Олны танил дүрүүдийг ашигласнаар үйлчилгээ, бүтээгдэхүүний борлуулалт өсдөг бөгөөд дүрийн бизнес дэлхийн \$2.3 их наядаар хэмжигдэж байна.

2018 оны 1-р сард анх Хандгай цуврал гарч эхлээд одоогийн байдлаар 100 гаруй цуврал комик гаргаж, сошиал дээр 68 мянган уншигч, дагагчтай болсон ба тэдний ихэнх хэсгийг 18-24 насны залуучууд эзэлдэг.

Энэхүү дүрийн гол үнэ цэн нь орчин үеийн монгол соёлыг агуулсан контентийг залууст санал болгох юм. Өдийг хүртэл залуучуудад чиглэсэн үндэсний дүр байгаагүй бөгөөд энэхүү хоосон орон зайг нөхөж, Монголын бүтээлч соёлын салбарыг хөгжүүлэх зорилготой билээ.




**Алсын хараа:** Тэд дараагийн 5 жилийн турш цахимаар комик стрипүүдээ тасралтгүй гаргах ба цаашлаад ном, нэмэлт контент, цахим бүтээгдэхүүн болон дайвар бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлсээр байх болно. Мөн тэд Монголын залуучуудын контент хэрэгцээг хангаад зогсохгүй олон улсын жишигт нийцсэн цуврал анимэшн хийхээр зорьж байна.

## d. Хөрөнгө оруулалтын процесс







Хөрөнгө оруулагч нар Blair Athol сингл молт торхтой вискигээр баталгаажсан сангийн нэгж эрх худалдан авах ба, 2022 оны 3-4 сард Хандгайн логотой хязгаарлагдмал буюу 50 ширхэг limited edition вискиг лонхлон зах зээлд борлуулна. Борлуулалтын орлогоос хөрөнгө оруулагчдад мөнгөн хэлбэрээр ногдол ашиг тараах юм.

2025 онд буюу хөрөнгө оруулалтын хугацаа 4 жилийн дараа дуусахад торхонд үлдсэн 15 жилийн настай вискиг дахин лонхлон зах зээлд нийлүүлж, хөрөнгө оруулагч нарт борлуулалтын орлогоос хуваарилснаар энэхүү хөрөнгө оруулалтын процесс дуусгавар болно.



## 3

## Хөрөнгө оруулалтын үе шат

	Вэбсайтад байршуулсан хөрөнгө оруулалтын проспектус болон видео, слайдуудтай сайтар танилцах.
	Хэдэн нэгж эрх худалдан авахаа шийдэж, захиалга өгнө. Үүний тулд вэбсайтад байршуулсан хөрөнгө оруулагчийн анкет болон захиалгын хуудас бөглөнө.
	Хөрөнгө оруулалтын талаар ямар нэг асуулт байвал манай сангийн менежерүүдтэй вэбсайт, утас, мэйлээр дамжуулан уулзалтын цаг товлож болно.
	Хөрөнгө оруулалтын гэрээг мэйлээр хүлээн авч танилцан, гарын үсэг зурж захиалгаа баталгаажуулах ба хөрөнгө оруулалтын төлбөрийн нэхэмжлэх хүлээн авч холбогдох дансанд төлбөрийг шилжүүлнэ. (DocuSign-аар гарын үсэг зурсны дараа өөийн биеэр заавал гарын үсэг зурж баталгаажуулах ёстойг анхаарна уу.)
	Хөрөнгө оруулалтын гэрээ, вискиний эзэмшлийг баталгаажуулах сертификатуудыг хүлээн авмагц бид Кастодиан банканд хадгалуулж, таны өмчлөлийг баталгаажуулах ба баталгаажуулсан даруйд танд мэдэгдэнэ.
	Ингээд виски торхондоо насжиж, лонхлогдосноор хөрөнгө оруулалтын өгөөж хүртэх хүртэл хүлээнэ.

## а. Лонхлох тухай

8, 10, 12, 15, 18 болон 21 гэх мэт вискиг ихэвчлэн лонхолдог онцгой жилүүд байдаг. Мөн бараг 12 нас хүрэхээсээ өмнө лонхлогдон зах зээл дээр зарагддаг тул 12 ба түүнээс дээш настай вискиг илүү дээд зэрэглэлийн, эрэлт өндөртэй болгодгийг дурьдах нь зүйтэй. Энэхүү төслөөр бид 12 болон 15 настай вискиг лонхлон борлуулахаар төлөвлөж байгаа нь ганц торхноос савласан гэдэг дээр үнэ цэнийг улам нэмнэ гэсэн үг юм.

Бид 2 үе шаттайгаар вискигээ лонхлох бөгөөд эхний шатанд 2022 оны 1-р улиралд 50 ширхэг Хандгайн лого бүхий лонхтой вискиг Монголд авчран борлуулж, орлогоос ногдол ашиг тараах бөгөөд 2025 онд үлдсэн ~178 лонхыг ижил процессоор борлуулна.

Хандгай ба ОРДА нь Шотланд дах лонхлогч компанид лого ба лонхны дизайныг өгч захиалгаар хийлгэх ба үйлдвэрлэлийн процесс Шотландад хийгдэж Монгол руу эцсийн бүтээгдэхүүн болон тээвэрлэгдэнэ.

Дорх хүснэгтэд лонхлохтой холбоотой хүлээгдэж буй өртөг, ногдол ашгийн хэмжээг харуулав:

Лонхлох зардлууд	2022	2025
Лонхны тоо хэмжээ	50	178
Вискиний өртөг	£1,785.71	£7,584.77
Лонхлох хөлс	£5,000.00	£17,800.00
Тээврийн зардал	£4,000.00	£14,240.00
НӨАТ	£1,198.41	£4,402.75
Гаалийн татвар	£182.70	£650.41
Удирдлагын зардал	£200.00	£200.00
Нийт зардал	£12,366.83	£44,877.93
Ногдол ашиг	£1,082.10	£3,926.82
Нийт дүн	£15,458.53	£56,097.42
<b>Нэг лонх вискиний үнэ £</b>	<b>£310.00</b>	<b>£320.00</b>
<b>Нэг лонх вискиний үнэ ₮</b>	<b>₮1,240,000.00</b>	<b>₮1,280,000.00</b>

## b. Хөрөнгө оруулалтаасаа хэрхэн гарах вэ?

- Та дараагийн худалдан авагчаа олж бидэнд мэдэгдснээр бид өмчлөлийг дараагийн хөрөнгө оруулагчид шилжүүлэх боломжтой.
- Эсхүл бид танд худалдан авагч олж өгөхөөр дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах боломжтой. (Хөрөнгө оруулалт 6 сарын lock up буюу түгжих хугацаатай болно.)
- 4 жилийн дараа вискиг лонхлон, эсвэл торхоор нь зарах бөгөөд үлдэгдэл дүнг хөрөнгө оруулагч нарт хуваарилснаар энэ удаагийн хөрөнгө оруулалт дуусгавар болно.

## 4 | Үйл ажиллагааны процесс ба бидний үйлчилгээ

1. Хөрөнгө оруулах вискиг сонгох;
2. Хөрөнгө оруулалтын хугацааг тогтоох - 4 жил;
3. Зардал болон хөрөнгө оруулалтын тооцоолол хийх;
4. Хууль, татварын өөр орчнуудад үйл ажиллагаа эрхлэх, виски нийлүүлэгч, лонхлогч, Эконтэтэй харилцах харилцаанд хөрөнгө оруулагч нараа төлөөлөлөх;
5. Проспектус, танилцуулга бэлтгэн хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлуудыг ханган, хөрөнгө оруулагч нарт хаалттай хүрээнд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлэх;
6. Өмчлөлийг баталгаажуулах;
7. Торхтой вискиг лонхолж эсвэл торхоор нь зарах;
8. Вискиг лонхлох, тээвэрлэх, борлуулах;
9. Лонхтой вискиг борлуулснаас олсон орлогыг хуваарилах;
10. Тогтмол тайлан, мэдээ бэлтгэн илгээх.

## 5 | Хууль эрх зүйн орчин ба эрсдэлүүд

### а. Хууль эрх зүй, татварын орчин

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын хүрээнд бид хөрөнгө оруулах шууд бус арга хэлбэрийг (Хувийн хөрөнгө оруулалтын сан) сонгосон бөгөөд “Трасс чэйн хувийн ХОС” ХХК нь “Нум сум Глобал” ХХК-г 100% эзэмшин, уг компани нь торхтой втскинд хөрөнгө оруулна. “Стэпп менежмент” ХОМК сангийн менежерүүдээр дамжуулан “Трасс чэйн хувийн ХОС” ХХК-ийн хөрөнгө оруулалттай холбоотой бүх удирдлагыг гүйцэтгэнэ.

### Татвар

Холбогдох хөрөнгө оруулалтын өгөөжид Их Британи болон Монгол Улсын эрх зүйн харьяаллын дагуу холбогдох орлогын албан татварыг ногдуулах бөгөөд үүнтэй холбоотой нарийвчилсан тооцоог энэ танилцуулгын холбогдох хэсгээс харж болно.

## Анхааруулга

Энэхүү танилцуулга нь хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг эсхүл хариуцлага хүлээлгэх баримт бичиг биш бөгөөд энд дурдсан агуулга нь зөвхөн хөрөнгө оруулалтын боломжийн талаар боломжит хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх зорилготой болно.

Хөрөнгө оруулагчид нь зөвхөн өөрийн нэрийн өмнөөс төлөөлөн шийдвэр гаргах болохыг анхаарна уу.

## б. Кастодиан банк

Хууль ёсны дагуу Blair Athol торхтой вискинд хөрөнгө оруулах процессыг бид Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмын хүрээнд бүтэцжүүлсэн болно. Ингэхдээ вискинд хөрөнгө оруулж буй компанийн хувьцаагаар баталгаажсан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Голомт банкны кастодианд бүртгүүлэн өмчлөл болон нэгж эрхийг баталгаажуулах юм.

Кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 3 банк Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бид Голомт банкыг хамтран ажиллахаар сонгосон нь шимтгэлийн зардал бага, гадаад болон дотоод хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай, нэгж эрхийн бүртгэлийн системийг Японы Номура компаниар хийлгэсэн тул найдвар, өндөр нууцлалтай, мөн J.P Morgan олон улсын Кастодиан банкны төлөөлөгч (sub-custodian)-өөр сонгогдсон зэрэг олон шалтгаантай билээ.

## с. Даатгал

Вискиний торх нь тухайн агуулахдаа даатгагдсан бөгөөд таны хөрөнгө оруулсан нэгж эрхийн үнэд 3 жилийн даатгалын үйлчилгээний төлбөрийг шингээсэн бөгөөд 3 жилээс өмнө худалдан борлуулах тохиолдолд шинэ өмчлөгчөөс үлдэх жилүүдийн даатгалын төлбөрийг суутган авна.



# 6 | Манай баг

## Үүсгэн байгуулагч нар



**Гэрэлмаа**  
CEO & Үүсгэн байгуулагч  
Бодлого, Технологи, Бизнес  
Инновацийн мастерийн зэрэг, UVSQ, France  
Математикийн бакалавр, KAIST

- 2021 -** **ADB** болон **Монгол банк** Зөвлөх  
Банкны систем, дижитал банкны дахин төлөвлөлт
- 2015- 2021** **Steppe Group** Гүйцэтгэх захирал  
Хүн төвтэй санхүү, технологийн компани
- 2019-2021** **AmCham Mongolia** ТУЗ  
ICT болон дижитал эдийн засгийн хорооны дарга
- 2013-2014** **OECD** Бодлогын шинжээч  
Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын орчны томоохон  
реформ дээр ажилласан
- 2013-2014** **UVSQ** Инновацийн мастер зэрэг  
Сэргээгдэх эрчим хүчний инновациар хэд хэдэн стартап
- 2008-2013** **KAIST** Бакалаврын зэрэг  
Математик болон Менежментийн шинжлэх ухааны хосолсон  
бакалаврын зэрэг



**Peter Choe**  
CTO & Үүсгэн байгуулагч  
Финтек, CS, Стартап  
UPenn CS мастер, NYU бакалавр  
KAIST CS Докторын зэрэг, ABD

- 2016-2018** **UPMC** Ахлах системийн инженер  
Эрүүл мэндийн үйлчилгээг  
цахимжуулах төсөл дээр ажилласан
- 2015-2016** **Seeds** CTO  
Barclays Techstars NYC стартапын  
хурдасгуур хөтөлбөрийн төгсөгч
- 2010-2012** **atDusk** CEO/Үүсгэн байгуулагч  
Судалгаан дээр үндэслэсэн хүн  
хоорондын нийгмийн харилцааг  
сайжруулах төсөл хэрэгжүүлсэн
- 2004-2012** **KAIST** PhD ABD  
Томоохон HCI конференсүүдэд  
оролцсон (UbiComp, CHI, Mobile HCI  
and ACM Multimedia)

## Багийн гишүүд



**А.Хэрлэнчимэг**  
CFO  
Санхүү, бодлого  
Глостерширийн их сургууль,  
Англи улс, M.B.A.



**Б. Солонго**  
COO  
Луизианагийн их сургууль, АНУ  
Бизнесийн удирдлага, Бакалавр



**М. Содгэрэл**  
Хөгжүүлэгч  
Нью-Йоркийн их сургууль,  
Абу Даби  
Компьютерийн ШУ, Бакалавр



**Н. Буяндэлгэр**  
Сангийн менежер  
Санхүү, хөрөнгө оруулалт  
Азийн их сургууль, Тайвань  
Санхүү удирдлага, Бакалавр



**Б. Хүслэн**  
Хуулийн зөвлөх  
Рэнмин их сургууль, БНХАУ  
Хууль, MA



**Nathnael Tsegaye**  
Хөгжүүлэгч  
Нью-Йоркийн их сургууль,  
Абу Даби  
Цахилгааны инженер, Бакалавр



**Р. Гантөмөр**  
Санхүүгийн менежер  
Кангвоны их сургууль, БНСУ  
Эдийн засагч, Мастер



**Г. Нандинбилэг**  
PR ба медиа  
МУИС  
Нягтлан бодох бүртгэл, Бакалавр



**Н. Урин**  
Дадлагажигч  
СЭЗИС  
Санхүү удирдлага, Бакалавр



**П.Пүрэвдулам**  
Санхүүгийн шинжээч  
СЭЗИС  
Санхүү удирдлага, Бакалавр



**Г. Мөнгөлжин**  
Дизайнер  
Йонсэй их сургууль, БНСУ  
График дизайн, Бакалавр

## Олон улсын зөвлөх баг



**Len Ball**

Дижитал шилжилтийн менежмент  
Канадын банк санхүү, Стартап  
Уилфрид Лориер их сургууль, Мастер



**Sung Won Park**

Нью Йоркийн хуульч  
JP Morgan Chase, Credit Suisse Санхүүч  
NYU Stern,  
Санхүү ба мэдээллийн технологи



**Charles Latchoumane**

Тархи судлалын шинжлэх ухаанч  
KAIST, Мастер, Доктор



**Hyukjae Jang**

БНСУ, Японы Лайн компанийн ахлах  
хөгжүүлэгч  
KAIST, Компьютерийн ШУ-ы Доктор



**Benny Lau**

Хөрөнгө оруулалт, Дойче банк  
Прайм брокерийн Ази номхон  
далайн бүс хариуцсан захирал.



**Joshua Foo**

Бүсийн захирал, Chainalysis  
GovTech Сингапур

## 7 | Холбоо барих

Утас: +976-75779444  
И-мэйл: invest@orda.mn  
Website: www.orda.mn

## 8

## Түгээмэл асуултууд

- Би вискиний торхон дээрээ очиж болох уу?

Хэрвээ та ИБУИВУ-д айлчлах бол та торхтой вискийг хадгалж байгаа агуулах дээр зочлох боломжтой. Ингэхдээ бидэнд урьдчилан мэдэгдэх ба бид тухайн агуулахад таныг очих талаар мэдэгдснээр та биечлэн очих боломжтой.

- Хэрэв миний торхтой вискинд эрсдэл учирвал яах вэ?

Таны торх вискиг бид Шотландад мэргэжлийн даатгалын үйлчилгээнд хамруулсан ба таныг хүсвэл илүү нарийн мэдээллээр хангах боломжтой.

- Миний торхыг хаана хадгалах вэ?

Торх нь Шотландад засгийн газрын зөвшөөрөлтэй, торхтой вискиний тусгай, татвараас чөлөөлөгдсөн агуулахад хадгалагдана

- Энэ торх нь жинхэнэ гэдгийг би яаж мэдэх вэ?

Их Британи Умард Ирландын вант улсын Засгийн газрын маш хатуу зохицуулалтын доор бүх торхууд “Delivery order” гэсэн бүртгэл хөтөлдөг ба торх бүрт дахин давтагдашгүй бүртгэлийн дугааруудыг олгосон байдаг тул хуурамчаар хийх, бүртгэлийн дугааргүй борлуулах боломжгүй байдаг.

## 9

## Хөрөнгө оруулалтын анхааруулга

“ОРДА Вэлф тэк” ХХК (цаашид холбоо хамааралтай бүх компаниудыг “ОРДА” гэх) нь гар утасны аппликейшн (цаашид “платформ” эсвэл “апп” гэх) дээр суурилсан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Бид платформуороо дамжуулан уламжлалт бус хөрөнгө оруулалтад хөрөнгийг хэсэгчилэн, эсвэл бүхэлд нь өмчлөх замаар оролцох боломжийг санал болгодог (цаашид “хөрөнгө оруулалт” гэх). Хөрөнгө оруулалтыг анхдагч болон хоёрдогч байдлаар платформ дээр санал болгоно. Энэхүү анхааруулгад манай платформуор дамжуулан үйлчилгээ авахтай холбоотой эрсдэл болон хөрөнгө оруулагч нарын зайлшгүй анхаарах ёстой зүйлсийг багтаасан болно.

Өнгөрсөн үеийн гүйцэтгэл ирээдүйн талаар ямар нэг баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагч өөрийн мөнгийг алдах эрсдэлтэй. Хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлт, хөрөнгийн хуваарилалт хийснээр ашиг олох, эсвэл алдагдал хүлээхгүй гэсэн баталгаа биш юм. Хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр тухайн хүний өөрийн зорилго, хугацаа, эрсдэл даах чадвар дээр үндэслэх ёстой.

ОРДА нь платформ дээр тавигдсан, эсвэл хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн ямар нэг хөрөнгө оруулалтын материал, танилцуулга, проспектус дээр дурьдсан аливаа хөрөнгийн багц, тоон мэдээллүүд нь ирээдүйд төсөөлсний дагуу явагдах, эсвэл үр өгөөжтэй байх талаар ямар ч амлалт, баталгаа гаргахгүй болно. Платформ дээрх бусад хөрөнгө оруулагч нарын хүртсэн өгөөжийг, эсвэл түүнтэй харьцуулахуйц ямар нэг хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгө оруулагч ирээдүйд хүртэнэ гэсэн үг биш юм.

Платформ дээрх хөрөнгө оруулалтууд ирээдүйд төлөвлөсөн бизнесийн зорилгоо биелүүлэх, хугацааны эцэст хөрөнгө зарагдах эсэх дээр ОРДА ямар нэг баталгаа гаргахгүй.

Хөрөнгө оруулагч нар өөрсдийн судалгааг хийж, Платформ дээрх тооцоолол, таамаглалд дангаар нь итгэж болохгүй бөгөөд бид таныг өөрн санхүүгийн зөвлөх, хуульч, нягтлан бодогч болон тухайн хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаар танд зөвлөж чадах ямар нэг мэргэжлийн хүнээс тусламж авч, ярилцахыг зөвлөж байна.

Үнийн трэнд болон бусад түүхэн дата, мэдээллүүд зөвхөн харьцуулсан загварчлалын зорилгоор ашиглагдсан болно. Гарч болох шимтгэл, зардлууд болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр бодит өгөөж, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл нь Платформ дээр төсөөлсөн дүнгээс зөрүүтэй байж болно.

Хөрөнгө оруулалтын хөрөнгө бүр онцгой бөгөөд өөрсдийн гүйцэтгэл, эрсдэл, ханшийн савалгаатай байдаг тул тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгөтэй шууд харьцуулах нь зохимжгүй гэдгийг анхаарна уу.

ИРЭЭДҮЙ ХЭЗЭЭ Ч ӨНГӨРСӨНТЭЙ ИЖИЛ БАЙДАГГҮЙ. ӨМНӨХ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ НЬ ИРЭЭДҮЙД ТИЙМ ДҮНГЭЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭН ӨСНӨ, ЭСВЭЛ ЯМАР НЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ОЛНО ГЭСЭН ҮГ БИШ. ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БУЙ ҮЙЛДЭЛ БҮРТЭЭ ТА ӨӨРИЙН ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ ХЭСЭГЧЛЭН ЭСВЭЛ БҮХЭЛД НЬ АЛДАХ ЭРСДЭЛ ХҮЛЭЭЖ БУЙГАА АНХААРНА УУ.

## **Хөрөнгө оруулалтын эрсдэлүүд**

Платформоор дамжуулан хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэй. Ямар нэг хөрөнгөд хөрөнгө оруулахаасаа өмнө проспектус, холбоотой татвар, зардлууд, бизнесийн болон санхүүгийн дүн шинжилгээ, танилцуулгыг анхааралтай уншиж, хянана уу. Мөн өөрийн нягтлан бодогч, хуульч эсвэл бусад зөвлөгөө өгөх боломжтой хүмүүстэйгээ урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Хөрөнгө оруулалтын хүрээнд дараах болон бусад эрсдэлүүд гаргах боломжтой:

- 1.Нэгж эрхээ буцаан зарж чадахгүй байх эрсдэл.** Платформоор санал болгож буй үнэт цааснууд нээлттэй зах зээл дээр арилжаалагддаггүй. ОРДА арилжааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр хичээн ажиллаж байгаа ч, тэр нь үргэлж амжилттай болно гэсэн баталгаагүй юм. Тиймээс хөрөнгө оруулагч нар өөрийн эзэмшиж буй нэгж эрх, үнэт цаасыг эргүүлэн зарах зах зээл хөрвөх чадвар маш бага, хязгаарлагдмал, мөн зарахтай холбоотой нэмэлт зардлууд гарч болзошгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.
- 2.Хөрөнгийг алдагдалтайгаар зарах эрсдэл.** Хөрөнгө оруулсан хөрөнгийн үнэ цэнэ анх авсан дүнгээс доошлох магадлалтай бөгөөд хөрөнгө оруулагч нар өөрийн оруулсан хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь алдах эрсдэлтэй. Мөн хөрөнгийн үнэ цэнэ өссөн ч өссөн дүн нь гаргасан зардлуудыг нөхөж барахгүй байх эрсдэлтэй.
- 3.Хөрвөх чадварын эрсдэл.** Уламжлалт бус хөрөнгийн суурь шинж чанар нь хөрвөх эрсдэл бага байх бөгөөд бидний зүгээс дараагийн худалдан авагч хүссэн үнийн дүнгээр эсвэл хүссэн хугацаанд гарч ирнэ гэсэн баталгаа гаргахгүй болно.
- 4.Уламжлалт бус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд.** Энэхүү эрсдэлүүдэд (i) хөрөнгийн жинэхнэ эсэх болон үүсэл гаралтай холбоотой маргаан, (ii) хөрөнгөд буруу хадгалалт, чанаргүй үйлдвэрлэл, осол, хулгай, байгалийн гамшиг, гал, болон бусад гадны хүчин зүйлсээс үүдэлтэй хоирол учрах (iii) өмчлөлтэй холбоотой хуулийн маргааны эрсдэлүүд, (iv) зах зээлийн эрсдэлүүд, (v)эдийн засгийн эрсдэлүүд (vi) залилангийн эрсдэлүүд болон бусад эрсдэлүүд орно. Бид платформ дээр санал болгох бүх хөрөнгүүдийг даатгалд хамруулахаар хичээж ажиллах ч гэсэн даатгалаар бүх эрсдэлүүдээс хамгаалх эсвэл бүх хөрөнгүүд даатгалд хамруулах боломжтой байна гэсэн амлалт гаргах боломжгүй юм.
- 5.Зах зээлийн трэндтэй холбоотой эрсдэлүүд.** Цуглуулагч, хөрөнгө оруулагч нарын дунд нэр хүнд өссөнөөс үүдсэн трэндийн дагуу хөрөнгийн үнэ цэн богино хугацаанд, эсвэл түр зуур өсөөд эргээд маш хурдан унах магадлалтай. Энэ төрлийн трэндийг таамаглахад бэрх бөгөөд хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

## Хавсралт - 1. Санхүүгийн тооцоолол

Орлого	2022E	2023E	2024E	2025E	Нийт
Вискийн үнийн өсөлт %	10.86%	10.86%	10.86%	10.86%	
Вискийн үнийн өсөлт GBP	£7,443.46	£8,251.82	£9,147.96	£10,141.43	
<b>Өгөөж</b>					<b>£0.00</b>
Ногдол ашиг	£1,082.10			£3,926.82	<b>£5,008.92</b>
<b>Нийт орлого</b>	<b>£1,082.10</b>	<b>£0.00</b>	<b>£0.00</b>	<b>£3,926.82</b>	<b>£5,008.92</b>
<b>Зардлууд</b>					
Хадгалалт ба даатгал				£65.00	<b>£65.00</b>
Кастодианы шимтгэл	£14.89	£16.50	£18.30	£20.28	<b>£69.97</b>
Хөрөнгийн удирдлагын шимтгэл	£148.57	£164.71	£182.59	£201.12	<b>£696.99</b>
Ерөнхий удирдлагын зардал	£608.04				<b>£608.04</b>
<b>Нийт зардлууд</b>	<b>£771.50</b>	<b>£181.21</b>	<b>£200.89</b>	<b>£286.41</b>	<b>£1,440.00</b>
Татварын өмнөх цэвэр ашиг	£310.60	-£181.21	-£200.89	£3,640.41	<b>£3,568.91</b>
Татвар	£0.00	-£18.12	-£20.09	£364.04	<b>£325.83</b>
Татварын дараах цэвэр ашиг	£310.60	-£163.09	-£180.80	£3,276.37	<b>£3,243.08</b>
Нэгж эрхэд ногдох цэвэр ашиг	£0.31	-£0.16	-£0.18	£3.30	
NAV	£7,024.88	£6,861.80	£6,681.00	£9,957.37	
CAGR	10.35%				
Татварын дараах нэгж эрхэд ногдох ногдол ашиг	£0.98			£3.56	

Бидэнтэй холбогдох:

Утас: +976-75779444

И-мэйл: [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

[www.orda.mn](http://www.orda.mn)

---